



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/106/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. АУДИТЫН ТАЙЛАН	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	18
4.3 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/117
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Батсүмбэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020378

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	81,485,148.01	82,273,528.63
33	АВЛАГА	549,801.10	351,973.52
33500	Бусад авлага	549,801.10	351,973.52
33510	Байгууллагаас авах авлага	549,801.10	351,973.52
35	БАРАА МАТЕРИАЛ	80,935,346.91	81,921,555.11
35100	Түүхий эд материал	288,600.00	922,700.00
35130	Эм боох материал	288,600.00	922,700.00
35400	Хангамжийн материал	80,646,746.91	80,998,855.11
35410	Бичиг хэргийн материал	23,850.00	37,500.00
35420	Аж ахуйн материал	976,800.00	648,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	879,000.00	1,621,500.00
35440	Түлш, шатах тослох материал	3,077,528.40	1,777,846.60
35450	Барилгын засварын материал	1,695,860.00	1,695,860.00
35460	Хүнсний материал	5,991,790.00	5,566,230.00
35470	Бусад хангамжийн материал	68,001,918.51	69,651,918.51
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	584,355,481.01	575,776,226.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	584,355,481.01	575,776,226.68
39200	Биет хөрөнгө	563,704,081.01	555,124,826.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	541,472,106.87	541,472,106.87
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,635,236.30)	(20,954,158.02)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	70,821,019.63	72,414,452.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,816,212.45)	(49,229,241.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,666,319.96	51,429,262.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,752,058.10)	(45,842,737.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,990,000.00	11,990,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,744,587.70)	(10,487,587.95)
39217	Ном	3,702,729.10	4,332,729.10
39300	Биет бус хөрөнгө	20,651,400.00	20,651,400.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,651,400.00	20,651,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	665,840,629.02	658,049,755.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	197,827.58	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	197,827.58	0.00
41300	Өглөг	197,827.58	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	95,327.58	0.00
41360	Бусад өглөг	102,500.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	102,500.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	665,642,801.44	658,049,755.31
51	Засгийн газрын хувь оролцоо	665,642,801.44	658,049,755.31
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	789,854,011.21	789,854,011.21
51200	Хуримтлагдсан үр дүн	(188,658,427.65)	(196,251,473.78)
51210	Өмнөх үеийн үр дүн	(185,645,119.70)	(188,658,427.65)
51220	Тайлант үеийн үр дүн	(3,013,307.95)	(7,593,046.13)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,447,217.88	64,447,217.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	665,840,629.02	658,049,755.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	783,884,400.00	758,229,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,764,000.00	823,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,764,000.00	823,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	13,499,000.00	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,265,000.00	823,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	769,120,400.00	757,405,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	692,567,300.00	685,913,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	692,567,300.00	685,913,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,750,200.00	13,821,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,750,100.00	13,821,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,802,900.00	57,670,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,802,900.00	57,670,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	786,897,707.95	765,822,246.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	786,897,707.95	765,822,246.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	605,441,700.17	635,282,266.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,036,637.63	473,697,975.03
210101	Үндсэн цалин	340,942,503.21	369,967,196.40
210102	Нэмэгдэл	77,056,227.42	46,203,628.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,350,740.00	14,005,205.95
210104	Урамшуулал	22,687,167.00	43,521,944.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,069,649.07	62,123,639.66
210201	Тэтгэврийн даатгал	41,845,954.55	44,244,031.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,372,812.38	4,611,087.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,951,638.10	3,538,505.37
210204	Ажилгүйдлийн даатгал	2,764,710.28	884,801.39
210205	Эрүүл мэндийн даатгал	6,134,533.76	8,845,213.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,643,494.20	56,942,812.64
210301	Гэрэл, цахилгаан	7,009,964.00	9,181,827.80
210302	Түлш, халаалт	30,553,530.20	47,745,984.84
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	15,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,043,442.00	2,350,115.00
210401	Бичиг хэрэг	718,570.00	570,850.00
210402	Тээвэр, шатахуун	1,099,532.00	1,594,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	55,340.00	184,665.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	170,000.00	0.00
2105	Нормативт зардал	34,820,387.00	20,624,760.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	689,400.00
210502	Хоол, хүнс	31,222,687.00	17,704,060.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,597,700.00	2,231,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	630,500.00	1,000,000.00

Төв аймгийн Батсүмбэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	630,500.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	505,000.00	362,000.00
210702	Дотоод албан томилолт	505,000.00	362,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,692,590.27	18,180,964.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	280,500.00	749,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	951,580.00	408,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,460,510.27	17,023,254.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181,456,007.78	130,539,979.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,750,100.00	13,821,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,750,100.00	13,821,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	115,691,210.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	115,691,210.31
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	504,024.00	1,027,269.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	503,924.00	1,027,269.16
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	100.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	140,201,883.78	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	140,201,883.78	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(3,013,307.95)	(7,593,046.13)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(3,013,307.95)	(7,593,046.13)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	789,854,011.21	64,447,217.88	(185,645,119.70)	668,656,109.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	789,854,011.21	64,447,217.88	(185,645,119.70)	668,656,109.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(3,013,307.95)	(3,013,307.95)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	789,854,011.21	64,447,217.88	-188,658,427.65	665,642,801.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	789,854,011.21	64,447,217.88	(188,658,427.65)	665,642,801.44
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(7,593,046.13)	(7,593,046.13)
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	789,854,011.21	64,447,217.88	(196,251,473.78)	658,049,755.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	769,120,400.00	757,405,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	769,120,400.00	757,405,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	692,567,300.00	685,913,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	692,567,300.00	685,913,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,750,200.00	13,821,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,750,100.00	13,821,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,802,900.00	57,670,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,802,900.00	57,670,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	767,210,700.00	748,961,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	767,210,700.00	748,961,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	585,754,692.22	618,421,720.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,008,372.86	473,697,975.03
210101	Үндсэн цалин	340,914,238.44	364,157,897.52
210102	Нэмэгдэл	77,056,227.42	52,013,622.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,350,740.00	14,004,572.21
210104	Урамшуулал	22,687,167.00	43,521,883.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,032,349.36	62,123,639.66
210201	Тэтгэврийн даатгал	41,808,651.84	44,244,031.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,372,812.38	4,611,087.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,951,641.10	3,538,505.37
210204	Ажилгүйдлийн даатгал	2,764,710.28	884,801.39
210205	Эрүүл мэндийн даатгал	6,134,533.76	8,845,213.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,798,976.00	55,643,130.84
210301	Гэрэл, цахилгаан	7,009,964.00	8,380,846.80
210302	Түлш, халаалт	27,681,012.00	47,247,284.04
210303	Цэвэр, бохир ус	108,000.00	15,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,841,720.00	1,840,565.00
210401	Бичиг хэрэг	160,000.00	183,500.00
210402	Тээвэр, шатахуун	829,200.00	739,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	54,120.00	184,665.00
210404	Ном, хэвлэл	73,000.00	116,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	397,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,725,400.00	220,100.00
2105	Нормативт зардал	32,404,774.00	20,118,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,000.00	100,000.00
210502	Хоол, хүнс	30,850,874.00	17,278,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,503,900.00	2,740,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	300,000.00	362,000.00
210702	Дотоод албан томилолт	300,000.00	362,000.00

Төв аймгийн Батсүмбэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,868,500.00	3,635,910.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,049,450.00	1,341,260.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,819,050.00	2,294,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181,456,007.78	130,539,979.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,750,100.00	13,821,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,750,100.00	13,821,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	115,691,210.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	115,691,210.31
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	504,024.00	1,027,269.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	503,924.00	1,027,269.16
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	140,201,883.78	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	140,201,883.78	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,909,700.00	8,444,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,909,700.00	8,444,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,909,700.00	8,444,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,909,700.00	8,444,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,909,700.00	8,444,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,909,700.00	-8,444,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	750,800,700.00	626,865,720.53	123,934,979.47	83.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	750,800,700.00	626,865,720.53	123,934,979.47	83.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	750,800,700.00	626,865,720.53	123,934,979.47	83.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	529,024,700.00	473,697,975.03	55,326,724.97	89.5
210101	Үндсэн цалин	333,797,300.00	364,157,897.52	-30,360,597.52	109.1
210102	Нэмэгдэл	119,999,400.00	52,013,622.12	67,985,777.88	43.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,480,000.00	14,004,572.21	4,475,427.79	75.8
210104	Урамшуулал	56,748,000.00	43,521,883.18	13,226,116.82	76.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,418,300.00	62,123,639.66	9,294,660.34	87.0
210201	Тэтгэврийн даатгал	50,257,400.00	44,244,031.58	6,013,368.42	88.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,290,300.00	4,611,087.80	679,212.20	87.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,232,200.00	3,538,505.37	693,694.63	83.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,058,000.00	884,801.39	173,198.61	83.6
210205	Эрүүл мэндийн даатгал	10,580,400.00	8,845,213.52	1,735,186.48	83.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,886,900.00	55,643,130.84	8,243,769.16	87.1
210301	Гэрэл, цахилгаан	8,380,846.80	8,380,846.80	0.00	100.0
210302	Түлш, халаалт	49,951,500.00	47,247,284.04	2,704,215.96	94.6
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	15,000.00	285,000.00	5.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,739,600.00	6,508,565.00	231,035.00	96.6
210401	Бичиг хэрэг	200,000.00	183,500.00	16,500.00	91.8
210402	Тээвэр, шатахуун	829,200.00	739,200.00	90,000.00	89.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	309,200.00	184,665.00	124,535.00	59.7
210404	Ном, хэвлэл	146,100.00	146,100.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	686,100.00	686,100.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,569,000.00	4,569,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	72,165,600.00	21,378,500.00	50,787,100.00	29.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	100,000.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	68,065,600.00	17,278,500.00	50,787,100.00	25.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	378,600.00	362,000.00	16,600.00	95.6
210702	Дотоод албан томилолт	378,600.00	362,000.00	16,600.00	95.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,187,000.00	6,151,910.00	35,090.00	99.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,891,000.00	3,857,260.00	33,740.00	99.1

Төв аймгийн Батсүмбэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,296,000.00	2,294,650.00	1,350.00	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	750,800,700.00	626,865,720.53	123,934,979.47	83.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	685,913,800.00	570,222,589.69	115,691,210.31	83.1
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	685,913,800.00	570,222,589.69	115,691,210.31	83.1
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	0	0	0.00	
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,886,900.00	56,643,130.84	8,243,769.16	87.3
320001	Орон нутгийн төсвөөс	64,886,900.00	56,643,130.84	8,243,769.16	87.3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42	42		100.0
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	25	25		100.0
620003	Үйлчлэх ажилтан	16	16		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		13,821,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		13,821,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		13,821,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		13,821,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		13,821,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		13,821,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		13,821,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		13,821,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, авлага, өглөгийн тооцоо нийлэх, хөрөнгийн дансны ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Батсүмбэр сумын Хүүхдийн цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтыг эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд Төв аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас 2021 оны 11 дүгээр сард хяналт шалгалт хийгдсэн бөгөөд ямар нэгэн төлбөрийн акт, албан шаардлага өгөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүү хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Батсүмбэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 786,897.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,869.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,508.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 765,822.2 мянган төгрөгийн 0.7 хувиар буюу 5,360.6 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Батсүмбэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд Тусгай зориулалтын шилжүүлгээс 685,913.8 мянга, орон нутгийн төсвөөс 57,670.4 мянган төгрөгийн санхүүжилтийг 100.0 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 13,821.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 748,961.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 7,814.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 630.0 мянган төгрөгийн номын фонд, нийт 8,444.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 8,444.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 823.5 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 26,996.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 26,833.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 352.0 мянган төгрөгийн авлага, өглөггүй тайлагнагдсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 81,921.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 575,776.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	549.8	352.0	(197.8)
Бараа материал	80,935.3	81,921.6	968.3
Үндсэн хөрөнгө	584,355.5	575,776.2	(8,579.3)
Нийт хөрөнгө	665,840.6	658,049.8	(7,790.9)
Өглөг	197.8	-	(197.8)
ЗГ-н оруулсан капитал	789,854.0	789,854.0	-
Хуримтлагдсан үр дүн	(188,658.4)	(196,251.5)	(7,593.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	665,840.6	658,049.8	(7,790.9)

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 8,579.3 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 717,557.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 67,000 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 784,557.6 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 33,756.7 мянган төгрөгөөр бууруулан 750,800.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 685,913.8 мянга, орон нутгийн төсвөөс 57,670.4 мянган төгрөг буюу 7,216.5 мянган төгрөгөөр дутуу санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 626,865.7 мянган төгрөгийг зарцуулж, 116,718.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 626,865.7 мянган төгрөг буюу 83.5 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 13,821.5 мянган төгрөг төвлөрч, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг зардалд 13,821.5 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 7,814.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 630.0 мянган төгрөгийн номын фонд, нийт 8,444.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 8,444.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийг бүлэг дотор зардлын хэтрэлт үүсгэж үндсэн цалин хөлсийг 10.0 хувиар буюу 32,188.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 134 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн төлөвтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант хугацааны эцэст 8,444.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгахад шалгагдагч байгууллага нь Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангаа бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн гүйцэтгэлийн тайлангаа иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 54.5, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал, үдийн хоол, дотуур байрны хүнсний материал, ахуй бараа материалыг зөвхөн нэг газраас худалдан авалт хийж байгааг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14,010.2 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд 8,444.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 5,566.2 төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Тайлант хугацааны эцэст 8,444.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 55,286.7 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-н тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад эд хариуцагчийг карт, тооцоо бодсон баримт, тооллогын комиссын илтгэх хуудас, өмч хамгаалах зөвлөлийн тэмдэглэл, байгууллагын удирдлагад танилцуулсан тэмдэглэл, тооллогын баталгаа хийгдээгүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...”, 72 дугаар зүйлийн 72.4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тооллогыг ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

Хүнсний материал 5,566.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарснаас түргэн муудах чанарын 1775.0 мянган төгрөгийн хүнсний материал байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хүнсний материалын чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллах, хүнсний материалын үлдэгдэл тооцоог тухай бүр хийж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төв аймгийн Батсүмбэр сумын Хүүхдийн цэцэрлэг	4	14,010.2					1	8,444.0	3	5,566.2
	ДҮН	4	14,010.2					1	8,444.0	3	5,566.2

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn